

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.01.01-2025.12.31

Contact:

T: (976) 7575 5511
M: ceci@upg.mn
W: www.ceci.mn

Location:

3F, Monnis Building, Stadium Orgil-22,
Great Mongolian street, 18th khoroo,
Khan-Uul district, Ulaanbaatar 17011, Mongolia

1. ТУЗ-ийн гишүүдийн нэрс, хараат бус байдлын мэдээлэл

№	Гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Хашбатын Гиймаа	ТУЗ-ийн дарга
2	Цогтжаргалын Ууганбаяр	Гишүүн
3	Наранбаатарын Урантуяа	Гишүүн
4	Баярбаатарын Баярмаа	Хараат бус гишүүн
5	Пүрэвдоржийн Ундрах-Эрдэнэ	Хараат бус гишүүн

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ийн ТУЗ нь 5 гишүүнтэй бөгөөд гишүүдийн 40 хувь нь хараат бус гишүүн болно.

2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, хэрэгжилт

ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 25/008 тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөн ажиллаж, журмын хэрэгжилтэд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хяналт тавьж ажиллаж байна.

ТУЗ-ын дэргэдэх хороо

№	ТУЗ-ын дэргэдэх хороо	Гишүүдийн тоо
1	·Аудитын хороо	3 гишүүнтэй
2	Эрсдлийн удирдлагын хороо	3 гишүүнтэй
3	Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо	3 гишүүнтэй

Хуралдааны тойм

Огноо	Хуралдааны төрөл	Ирц (%)	Хэлэлцсэн асуудал	Гаргасан шийдвэр
2025.01.21	Биет хурал	100%	1. Өмнөх хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар мэдээлэл өгөх 2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан танилцуулах 3. Гадаад орчны судалгаа болон ББСБ-ын салбарын тайлан 4. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө танилцуулах	1. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг батлахаар шийдвэрлэв.
2025.04.24	Биет хурал	100%	1. Компанийн 2025 оны 1-р улирлын үйл ажиллагааны тайлан 2. Компанийн дунд хугацааны стратегийн хувилбарын танилцуулга	1. LOS,LMS, кредит карт болон киоскын судалгааг илүү дэлгэрэнгүй хийж, зардал үр ашиг, эрсдлийг тооцоолж дахин танилцуулахыг үүрэг болгон шийдвэрлэв.

Огноо	Хуралдааны төрөл	Ирц (%)	Хэлэлцсэн асуудал	Гаргасан шийдвэр
2025.05.27	Биет хурал	80%	1. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийг хэлэлцүүлж, батлах 2. Компанийн зээлийн үйл ажиллагааны систем болон зээлийн удирдлагын системийн шинэчлэлт, шинэ системийн худалдан авалт, нэвтрүүлэлтийн төлөвлөгөө танилцуулах	1. Компанийн 2025 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлахаар шийдвэрлэв. 2. Компани зээлийн үйл ажиллагааны LOS, LMS нэвтрүүлэх, шаардлагатай системийг худалдан авахыг зөвшөөрч шийдвэрлэв.
2025.09.03	Биет хурал	100%	1. 2025 оны хагас жилийн гүйцэтгэл 2. Төслүүдийн явц 3. Бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	1. Эрэн сурвалжлагдаж байгаа, эргэлзээтэй болсон, чанаргүй зээлийн мэдээлэл бэлтгэхийг даалгав. 2. Өрсөлдөгч нарын зээлийн хүүний судалгаа улирал тутам хийж, өөрсдийн хүүний өөрчлөлтийг улирал тутам шинэчилж байхыг даалгав. 3. Бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг дэмжиж шийдвэрлэв.

КЗК-ыг хэрэгжүүлэл хүрээнд дараах журмуудыг батлан үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.
Үүнд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам
3. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хорооны журам
4. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны журам
5. Сонирхлын зөрчилтэй тэмцэх журам
6. Мэдээллийн ил тод байдал тайлагналын журам
7. Залгамж халааны бодлого
8. Цалин урамшууллын бодлого
9. Эрсдлийн удирдлагын журам
10. Компаенсын үйл ажиллагаан журам
11. МУТСТ-ийн үйл ажиллагааны журам, хөтөлбөр
12. Ёс зүйн дүрэм
13. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

ТУЗ-ийн дэргэдэх “Эрсдэлийн удирдлагын хороо”-г шинээр байгуулан тус хороогоор дамжуулан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. “Эрсдэлийн удирдлагын хороо” нь компанийн эрсдэлийн бүртгэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээтэй танилцан цаашид эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах зөвлөмжийг гарган 2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дотоод аудитын хорооны гишүүдийг шинээр томилж, тус хороогоор дамжуулан дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Тус хорооны журмыг баталж, үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Мөн Аудитын хорооны 25/001 тоот тогтоолоор дотоод аудитын баг томилж 2025 оны 11 сарын 10-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал хугацаанд аудитын хяналт шалгалтыг компанид хийсэн. Аудитын багийн шалгалтын дагуу дотоод аудитын тайлан болон санал зөвлөмжийг компанид хүргүүлэн ажилсан байна.

Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороог нэгтгэн шинээр зохион байгуулж, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороог байгуулж, хорооны гишүүдийг шинээр томилж, цалин урамшууллын бодлого, залгамж халааны бодлогыг 2026 онд шинэчлэн боловсруулахаар төлөвлөж байна. Гүйцэтгэх захирлын болон ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын гэрээг хэлэлцэн ТУЗ-д танилцуулан баталсан болно.

БОНД хэрэгжүүлэх хүрээнд Тогтвортой хөгжлийн 17 зорилт, Тогтвортой санхүүжилтийн 8 зарчимд нийцүүлэн компаний Тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулан батлуулахаар төлөвлөж байна.

Компани нь цорын ганц Хувьцаа эзэмшигчтэй бөгөөд компанийн эцсийн өмчлөгч, Хувьцаа эзэмшигч нь “Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн даргын үүргийг давхар хэрэгжүүлэн ажилдаг болно.

Гишүүний нэр	Албан тушаал (Дарга/Гишүүн)	Хорооны гишүүнчлэл	Хурлын тоо	Цахим	Биечилсэн	Ирц %	Санал хураалт	Санал өгсөн	Хэлэлцэх асуудлын оролцоо
Х.Гиймаа	Дарга	Аудитын хорооны гишүүн	36	32	3	97,2%	36	36	100%
Ц.Ууганбаяр	Гишүүн	Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо болон Эрсдлийн удирдлагын хорооны гишүүн	36	32	4	100%	36	36	100%
Б.Баярмаа	Гишүүн	Аудитын хорооны гишүүн	25	22	3	100%	25	21	84%
П.Ундрах-Эрдэнэ	Гишүүн	Эрсдлийн удирдлагын хорооны гишүүн	36	32	4	100%	36	35	97,2%
Н.Урантуяа	Гишүүн	Эрсдлийн удирдлагын хорооны дарга болон аудитын хорооны гишүүн	16	15	1	100%	16	16	100%

Тайлан бэлтгэсэн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: _____ Огноо: _____